

S.Damdinjav together with his wife gives interview to Irina Morozova (some translation into Russian) in their flat in Khovd in August 2012.

- Ардчилсан нийгмийн үед амьдрал ахуй тань хир зэрэг өөрчлөлт гарав, социализмын үед ямар байв, ардчиллын үед ямар байв. Тийм юмнуудын талаар ярилцах гэсэн юм. (**Interpreter**)
- **Можно спросить. Та хэдэн оны, хаана төрсөн бэ? И полное имя, если можно, тоже сказать.**
- Та хэдэн онд, аль нутагт төрсөн бэ?
- Би 1936 онд Эрдэнэбулган сумын нутагт төрсөн. Одоо 77-той.
- **Interpreter:** Он родился в 1936 году на территории сомона Эрдэнэбулган. Ему сейчас 77 лет.
- **А можно он свое полное имя произнесёт?**
- **Interpreter:** Аа... да, это здесь есть.
- **Родители кто были, аав ээж?**
- Танай аав ээж юу эрхэлдэг хүн байв?
- Малчин улсууд байсан.
- **Interpreter:** скотоводами.
- **А детство своё, что помнит?**
- Та хүүхэд ахуй цагаа хаана өнгөрөөсөн бэ, юу хийдэг байсан бэ?
- Гүй яахав мал хариулаад, малын дэргэд байгаад л, тэгээд л нэг сургуульд суугаад, 4-р анги төгсөөд л, тэгээд амьдралын эрхээр хөдөө гарч, сургуулиа хаяж хөдөө гарч мал маллаад. Тэгээд гүйж явж байгаад аймгийн төв орж ирээд бие дааж жолооч болсон. Бие дааж жолооч болно гэдэгт онолын ном, дүрмийг одоо ерөөсөө ширхэгчлэн цээжилдэг байсан, тэр үед бид нар бол. Жишээлбэл, карубетор гэх дээр тэр карубетор ямар үүрэгтэй юм, ямар зохион байгуулалттай юм, яаж яаж ажилладаг юм гэдгийг нь бүгдийг нь сурч байж, цээжилж байж, тэгж шалгуулаад жолооч болж байсан. Дүрэм бол бас тэгнэ. Дүрмийг ерөөсөө эхнээс нь аваад адаг хүртэл нь цээжилчдэг байсан. Тэрнийгээ ерөөсөө ямар ч хүн асуусан ч хариулдаг, саадгүй давхиж байдаг байсан.
- Тийм юуны тухай ном сонин дээр үед ирдэг байсан уу?
- Сонин ирж байгаагүй, онолын ном ирдэг байсан.

- **Interpreter:** Он окончил 4-ый класс и провёл своё детство со своими родителями. Пас овец и коз. И после окончания 4-ого класса, по требованию жизни он ещё раз в худоне работал. Когда он стал взрослым, он вернулся в центр аймака и самостоятельно стал шофёром. Он стал читать книги про машинах и хорошо зубрил правила машины и как водить машины. И таким образом он сам стал шофёром.
- Тэгээд тэр руль сурах юмуу, тэр онолын номыг нэг жолооч машиныхаа капотыг сөхчихөөд юм хийж байвал, тэр чинь юу гэдэг юм энэ стачер гэдэг юм, энэ чинь юу юм энэ чинь карбулюр гэдэг юм гэж асуугаад л цөмийг нь үзчихээд, тэгээд номыг үзчихээд. Аа энэ чинь тийм үүрэгтэй юм байна гэж ойлгоно. Тэгэж бид бие дааж сурч байсан. Тэр үед чинь түүнийг бүрэн мэддэг ч хүн байна, мэддэггүй ч хүн байна. Бид чинь номыг нь олоод авчихсан болохоор нэг ч бүх зүйлийг мэддээд авчихдаг байхгүй юу. Тэгээд сонирхолтой байсан болохоор нэрийг нь мэдээд авхад ч амархан. Нэг жолооч капотоо сөхчихсөн байхад наад зах нь 5 зүйлийн нэрийг мэдээд авна. Тэр чинь том олз шүү дээ, тэр дотор нь юу байдаг юм, яадаг юм гэдгийг бүгдийг ойлгож мэдээд авдаг. Рульд бол хүний машиныг гуйж авч унадаг.
- **Interpreter:** ... и он подойдёт к ним и спрашивает о машинах, что это?.. И таким образом он знал всё про машинах самостоятельно. И попросили людей чтобы вместе водить машину на дальных дорогах. И таким образом стал шофёром. В то время не было автошколы.
- *А где вы находил книги о машинах?*
- Та тэр машины эд ангийн тухай дүрэм онолын номоо хаанаас авсан бэ?
- Тэр их ховор байдаг байсан. Ер нь л одоо их л хайж байж, амьтан хүнээс гуйж байж олно доо. Тэрнийгээ би ганцаараа эзэмшихгүй, хоорондоо дамжуулж хэрэглэнэ. Тэгж сурдаг байсан.
- Та тэрийг хүнээс гуйж авч байсан юм уу?
- Өө тэгэлгүй яахав. Нэг нэгнээсээ гуйж авна шүү дээ. Тэр тийм ном олоод авчихсан байна лээ гэвэл тэрүүнтэй найзалж, очиж түүнээс 10 хоног гуйж авна. Тэгээд тэр дотроос хэдэн зүйлийг сурч авна. Нөгөөдөх нь эргүүлээд авна. Тэгж дамжуулж байж л, тэр үед чинь хүн сурахын төлөө тэмцэж байсан учраас, ямарч аргаар ч гэсэн яагаад ч гэсэн юмыг олж авна. Сурах

гэж тэмцэж байгаа хүн, нэг олж авсан юмнаасаа их юм сурна шүү дээ. Тэр үед чинь жолооч болох хүнийг их нарийн шалгаж авдаг байсан. Мэдрэлийг шалгана, хөл гарыг шалгана, хараагийг нь шалгана. Бүх юмны шалгуур их хатуу байсан. Одоо бол тийм юм байхгүй. Тэгээд эрүүл, санаачлагатай, сэргэлэн, чадалтай, бас гайгүйхан тийм хүмүүсийг авдаг байсан шүү дээ.

- **Interpreter:** Он просил одного приятеля, в то время это книга была очень редкая. Когда он найдёт 10 дней прочитал. А потом у друга спрашивал чтобы прочитать ещё 10 дней. Таким образом они прочитали. В то время поставили очень высокие требования шофёрам. Проверили их зрения... и каждый 10 лет поставил уровень шофёрам, шофёр 1-ого уровня, 2-ого уровня и тогдали.
- ***Тоесть как вот он начал работать уже официальным шофёром, с какого года?***
- Та одоо хэдэн оноос эхэлж албан ёсоор замд гарч, жолоо барьж эхэлсэн бэ?
- Би 1958 оны 1 сараас эхэлж жолооч болж, машин авч гарч эхэлсэн.
- 1958 года в январе.
- ***А что была за машина, что он перевозил? Пассажиров или грузы какие?***
- Таны машин ямар машин байсан юм бэ тухай үед? Та ачаа зөөдөг байсан уу, хүн зөөдөг байсан уу?
- Аа 63 гэдэг машин барьж байсан. Бензины цистенер барьж байсан. Тээврийн Зил-164 барьж байсан. Сүүлдээ 30 гараад 30 машин барьж байсан. Тэгээд сүүлдээ 469 барьж, дандаа том албаны хүмүүст үйлчилдэг байсан. Намын дагуу сайд нарын зөвлөл, гадаад дотоодын бүх хүмүүст үйлчилдэг тийм албанд. Тэгээд жолооч болоод арван хэдэн жил болоод 2-р зэргийн курст явсан, тэгээд 2-р зэргийн жолооч хийдэг болсон. Дахиад 10-аад жилийн дараа тэр нэгийн курсанд суугаад 1-р зэргийн жолооч болсон. Тийм л юм хийж байлаа.
- **Interpreter:** сначала он водил 63 такая машина была. Потом водил бензевоз. Потом Зил-130 новая машина появилась. Потом стал шофёром

директоров. Водил УАЗик маленький. И он стал шофёром первого разряда, класса. Он сдал экзамен.

- ***С какого года он работал шофёром директоров?***
- Тэр дарга нарын машиныг та хэд оноос эхэлж барьдаг болсон бэ?
- Дарга нарын машиныг 1984 оноос эхэлж 90 он хүртэл барьж байсан.
- **Interpreter:** с 1984 года до 90-го года.
- ***А кого вы возили? Это был директор чего, какого предприятия?***
- Тэгээд тэр ямар ямар дарга цэрэг нар байсан бэ? Юу юуны дарга байсан бэ?
- Гүй одоо надад болох дээр дандаа гадаад орны улсууд. Энэ л одоо монголыг сонирхож байсан ажил төрлөөр явж байсан гадаадын улсууд. 12 орны хүнд үйлчилсэн байдаг юм би. Аймгийн төв хорооны томчууд хөдөө явнаа, Сайд нарын зөвлөлийн томчууд хөдөө явна, дандаа тийм юманд би томилогддог юм. Урьд нь болохоор социалист хөдөлмөрийн бригад, дараагаар нь саятны хөдөлгөөн гэж хөдөлгөөн байгуулж явдаг байсан. Тэгэхдээ бүх хатуу норм төлөвлөгөөг биелүүлдэг байсан. Норм төлөвлөгөөг сайн биелүүлдэг. Ер нь л сар бүр тогтмол норм төлөвлөгөөг давуулж биелүүлдэг байсан. Засгийн шагналыг дэс дараагаар авдаг байлаа. Явсаар байгаад л Алтан гадас аваад л тэгээд л тогтсон.
- **Interpreter:** он большинство случай привозил делегатов из 12 стран и ещё директор Оргкомитета, Аймачной революционной партий и тогдали. И из государства поставил план. И он каждый месяц перевыполнял этот план. И из государства он получил награды. Почти все награды. В конце концов ему дали орден Полярной звезды, самый высший орден государства.
- ***Скажите, что очень интересно. Очень впечатляет, как он работал. А вот эти делегаты из 12 стран... вот такая интересная жизнь у него была. Он все видел; что он помнит о них? Может быть, он какой-нибудь случай расскажет?***
- Тэгээд уулзаж байсан хүмүүс дотроос таньд үлдсэн сэтгэгдэл юу байна? Тэр хүмүүсийн тухай санаж байх юм байна уу?
- Тэр үед бидэнд санал гомдлын дэвтэр, эрэлт хүсэлтийн дэвтэр гэж байсан. Тэгэхдээ тэр дэвтэр дээр тэр улсууд бүгдийг сайхан бичиж өгдөг

байсан. Одоо янзтай сайхан бичиж өгнө, баярласан талархласнаа. Тэгээд энэ ардчилал гарч ирснээс хойш, би малчин болоод хөдөө гарсан байхгүй юу би. Энд гэрт үлдсэн улсууд, хүүхдүүд миний хоёр дахин жолооны сургуульд сурч байсан номнууд, тэр сайхан санал гомдлын бичиж байсан дэвтэрүүд, түүгээр сар жилээр шалгаж дүгнэдэг байсан бүх зүйлүүдийг хүүхдүүд цөмийг устгаад хаячихсан байсан. Бид хоёр малчин болоод хөдөө гарчихсан. Бид хоёрын авч байсан бүх гавъяа шагналын янз бүрийн бичиг сачиг юу ч байхгүй. Тэгээд ардчилал гараад нээх ард түмэн ядуураад, түлээ түлш байхгүй, юу ч байхгүй үед энэ бүхнийг шатаагаад дуусгасан байна. Тэгэхдээ одоо хэдэн тэмдэг үлдсэн. Хоёр, 4-н саятны нэг юм байгаа байх.

- **Interpreter:** когда началась демократизация, он перестал быть шофёром и стал жить в худоне в качестве сктовода.
- Хамгийн анх үйлчилгээнд гараад Ираны шахд явж байсан, Солонгосын улсуудтай явж байсан, Молдаваас ирсэн атомын том эрдэмтэнтэй хамт явж байсан,Украйн, Киргиз, Казакстан, Америкийн улсууд, Хятадын төлөөлөгчидтэй явсан, Вьетнамын төлөөлөгчидтэй явж байсан. Ийм 12 орны улсуудтай явж байсан. Тиймэрхүү үйлчилгээ хийж байсан. Тээврийн машинд байхад чинь жинхэнэ норм төлөвлөгөөний төлөө л явж байсан. Төлөвлөгөөт эдийн засаг гэдэг чинь норм төлөвлөгөөгөө давуулж биелүүлж байдаг, тэгж байж л сайн нэр сонсож байдаг. Тэрүүгээрээ амьдраад явж байдаг, тийм л байсан.
- **Interpreter:** Большинство из этих делегатов были учёные которые изучили Монголию. Они были делегаты из Казахстана, из Киргизии, из Украины, из Америки, из Вьетнама, из Китая, из Молдавии.
- Энэ нөгөө түүний авто курсанд сурч байсан сургууль нь. (*said by his wife*)
- Энэ 2-р зэргийнхүү, 1-р зэргийнхүү ?
- Нэг нь дээр нь байна.
- **Interpreter:** Это сертификат, когда он получил “Водитель 1-го разряда” класса. В начале демократизаций трудно стало жить его детям пока его родители жили в худоне. Они сожгли все нужные документы, записки где каждые делегаты оставили самые хоршие впечатление о нём, о его работе. Но к сожалению, его дети сожгли.

- *Можно я всё это сфотографирую?*
- Эдгээрийн зургийг авч болох уу, ах аа?
- Аа болно оо.
- *Я прямо всё сфотографирую, всё, что мне покажут.*
- *А это когда он... значит, периодически он ещё учился в автошколе. И все были из одного аймака, кто были в автошколе, да?*
- Энэ хүмүүс бүгд Ховд аймгийн хүмүүс байсан уу?
- Үгүй, бүх аймгуудаас очсон. Тал талын бүх аймгуудаас. Аймгаас нэг л хүнийг 1-р зэргийн жолоочыг шалгаруулж авна. Бүх аймгуудын бас Улаанбаатарын байгууллагуудаас. Тэр чинь их ховор байсан юм. 1,2-р зэргийг авахад шалгуур өндөр. Ямар нэгэн хэрэг зөрчилгүй. Энэ Зөвлөлтөөс манай байгууллагад ирж байсан шагнал, тэргүүний жолооч гэж.
- Зөвлөлтийн гавшгайч, шалгаруулж түүнд гавшгайч болгосон. *(said by his wife)*
- **Interpreter:** Из Советского союза ему дали тоже орден. Это шофёр который миллион км ехал. Поэтому ему дали такой диплом.
- Тэгээд 3 дахийг нь бас авсан байхгүй. Ажлаа гүйцэтгэхчээд шагналаа авах гэтэл ардчилал гараад замхраад алга болсон. Ажил нь батлагдчихсан, шагнал нь батлагдчихсан байж байтал ардчилал гарч ирээд бүх юм бужигнаад, тэр үеэр бүх юм устаад тэгээд 3 дахиа авч чадаагүй.
- **Interpreter:** 3-ый диплом он тоже получил. Но при демократизации все исчезло и ему не дали.
- Одоо үүний 3 дахь нь тийм юмтай Баасанжав гэж хөгшнийд тод байж байгаа. Түүнээс өөр хүнд байхгүй. Түүнд 1, 2, 3 гэж дараагаар бий. Надад бол 1, 2 дахь нь бий. Минийх 3 дахь нь байхгүй. Ажлаа гүйцэтгэсэн боловч шагналтай энэ нь ирэх гэж байтал ардчилал гарч ирээд тэгээд бужигнаад алга болсон. Гурав дахиа жинхэнэ авсан хүн гэж Баасанжав гэж хөгшин байдаг юм.
- **Interpreter:** здесь ордена...
- Энэ ингэж эхэлдэг юм. Энэ 5, 6, 7-р таван жилийн гавшгайч. Тэр болохоор 50, 60, 70, 80, 90 жилийн ойн медалиуд.

- **Interpreter:** медали передового работника 5-ти летки, 5-ого 6-ого, 7-ого пяти летка. Это юбилейные медали. Это Полярная звезда, это медаль за лучший шофёр.
- Ийм гоё залуу байсан юм. Одоо чөтгөр боллоо.
- Наадах чинь 77- той. Би 76-тай. Манай хүүхдүүд цөм ажил төрөл хийгээд, цөм сайхан явж байгаа. Та бүгдийн буянд сайхан амьдарч байна. *(said by his wife)*
- Хичнээн хүүхэдтэй вэ, эмээ?
- Гурван охин, гурван залуутай. Цөмөөрөө одоо ажилчин албан хаагч нар. Цугаараа ажил төрөлтэй. Олон ач зээ нартай. *(said by his wife)*
- **Interpreter:** У них 6 детей. 3 мальчика, 3 девочки. Все они работают.
- Бид хоёр одоо 56 онд суугаад, одоо 67 жил болж байна. Энэ 19- той, би 18-тай суугаад, энэ 77-той, 76-той, тэгээд одоо 66-67 жил болж байна аа, нэг гэрт амьдраад.
- **Interpreter:** они живёт вместе с 56-ого года когда им было 18, 19 лет.
- *Аан.. с тех пор они вместе живут. Вот это уже больше пяти-десяти лет.*
- Энэ дандаа баярын бичиг, сайшаалын бичгүүд бүх л юмнууд байгаа юм.
- Их гоё юмнууд байсан. Маш их жуух бичиг том юмнууд байсан. Хүүхдүүд түлээд хаячихсан. *(said by his wife)*
- Тээврийн байгууллагын хүндэт жуух бичиг байсан, тэгээд одоо байхгүй.
- **Interpreter:** Здесь награды. Остальные дети сожгли, кроме этих.
- *А они случайно сожгли?*
- Тэд нар мэдэхгүй шатаачихсан юм болов уу, эсвэл хэргээр шатаачихсан юм болов уу?
- Мэдэхгүй л шатаачихгүй юу. Бид нарт эргээд хэрэг болно гэдгийг мэдэхгүй л байхгүй.
- **Interpreter:** Он говорит, случайно.
- **А она кем работала?**
- Та ямар алба хашдаг байсан бэ?
- Би ахуй үйлчилгээнд 40 жил оёдолчин хийсэн. Ерөөсөө багадаа оёдолд, үйлдвэрт ороод тэгээд 90 онд тэтгэвэрт гарсан.
- **Interpreter:** она шила одежды.

- **А она работала на каком-то предприятий, да?**
- **Interpreter:** Конкретно аймочного обслуживания. Там она работала всю жизнь.
- **А когда он возил иностранные делегации, там директоров, то там какая машина была?**
- Та даргын жолооч болохдоо УАЗ 469 барьдаг байсан уу?
- **Interpreter:** УАЗИК- 469. Такая машина, простенькая.
- Бид нар та нарт энэ бүх юмнуудаар баталгаажуулж байгаа шүү. Үнэн ч юмуу худал ч юмуу үзээгүй юм чинь хэлхэд хэцүү шүү дээ. Тэгээд одоо баталгаажуулж байгаа юм. *(said by his wife)*
- **А вы в партии состояли?**
- Та намын гишүүн байсан уу?
- Намын гишүүн.
- **А с какого года?**
- Насаараа. Бид нар чинь залуухан байхдаа л намд ороод л. Намын гишүүнд чинь маш их шалгуур авдаг байсан ш дээ, тэр үед чинь. Гэр бүлийн тогтвортой, үр хүүхэдээ хүмүүжүүлэх, ажлаа сайн хийх гээд л бүх юмыг тэр үед чинь хийж байж тэгээд намын гишүүнд ордог байсан. Их хатуу байсан. *(said by his wife)*
- Та хэдэн онд намын гишүүнд орсон бэ?
- 80-н хэдэн онд орсон.
- **Interpreter:** в начале 80-ого года.
- **В начале 80-го года, да? Как его приняли в партию? Он может рассказать, как это было ?**
- Таныг намд орохдоо хэрхэн хүлээж авсан бэ? Дээр үед намд гишүүнээр авахдаа их бэлтгэдэг байсан гэсэн ш дээ өмнө нь.
- Их шалгуураар авна. Хэрэг зөрчил юу байна, ямар хэрэг гаргаж байв шалгаад тэгээд ажилчдын хурлаар оруулж, тэгээд намын үүрийн хурлаар оруулаад тэгээд баталж, намын гишүүн болгодог.
- Их хатуу шалгуураар авна. Гэр бүл тогтвортой, үр хүүхдийн хүмүүжил, хүүхэд ямар сурлагатай байсныг хүртэл шалгаж байсан. Тэгээд соёлын довтолгооны үеэр гэрийн ариун цэвэр үзээд соёлын довтолгооны

үнэмлэх өгөөд бүх юмаар шалгаж үзэж байсан. Тэрнийг тэнцсэн хүмүүс намын гишүүнд авч байсан. **/said by his wife/**

- **Interpreter:** Государство делал чень много требования. Они проверяли: нарушали ли закон, есть ли ему преступления, даже как учились его дети, и ещё семейное состояние, как живёт, как относиться с женой и детьми. Так всё проверяли. Из партии организовали заседания. И потом он стал членом партий.
- ***А какие-нибудь вопросы ему задавали? Ему надо было экзамен сдавать по истории партии?***
- Танд ямар нэг асуулт тавьж байсан уу, гишүүнээр элсэх гэж байхад ?
- Тавилгүй яахав. Ухаан нь одоо орчин үед юу явагдаж байна, намын ажил яаж явагдаж байна, сонин хэвлэл дээр юу гарч байна.
- Бид нар чинь хурлын товчлол хийнэ, их хурлын товчлолтой байна. Тэрийгээ шалгуулна, дүн тавиулна. Том дэвтэр дээр. Хурлын шийдвэрийг бичнэ. **/wife/**
- Одоогийн жолооч нар мэдлэг байхгүй. Зөвхөн дүрэм заана, дүрмээ бүрэн зааж чадахгүй, бүрэн сурч чадахгүй. Онолын ном, онолын талын юмнуудыг ерөөсөө мэдэхгүй.
- Машин эвдэрлээ гэхэд тэрнийг яаж засдагийг ерөөсөө заахгүй л байгаа ш дээ.
- **Interpreter:** Очень много политические вопросы ему задавали. Какие политические задачи в то время были, и что люди делают, как живут, и ещё они записывали решения государственного дума. И они проверяли и оценили эти записки.
- ***А он помнит ли, как он ответил на вопросы о политических задачах партии?***
- Та нөгөө намын бодлогын талаарх асуултанд яаж хариулж байсан бэ? Бүгдэнд нь хариулж байсан уу?
- Өө гайгүй хариулж байсан. Овоо гэж үзэж байсан.
- Манай хүн урлаг уран сайханд тэргүүлж байсан. Уртын дуу сайн дуулдаг. Ардын дуу, уртын дуу сайн дуулна. Авьяастай. Их мундаг. Өчигдөр бид найранд очоод, манай нагацынд очоод, өдөр гуравт ирлээ, тэгээд тэр найранд манай хүн уртын дуу дуулаад, ер нь одоо уртын дуу

дуулдаг залуучууд байхгүй байна ш дээ, тэгээд найр сайн хөгжөөж өгсөн гээд бид нарт шагнал өгсөн. /wife/

- **Interpreter:** Он очень хорошо ответил на вопросы. Ещё он также занимается искусством. Очень хорошо поёт национальные песни. Вчера он много пел на свадьбе.
- 90-оноос өмнө бид нар чинь төлөвлөгөөт нормын ажилтай. Жолооч хүн гэртээ их цөөхөн хонодог байна лээ ш дээ. Бас өөрөө хувийн төлөвлөгөөтэй. Хувийн төлөвлөгөөг биелүүлэхийн тулд бас байгууллагаас төлөвлөгөө өгнө. Тэрүүнийг биелүүлэхийн тулд өөрөө хувийн төлөвлөгөө хийнэ. Тэгээд өнөө шөнө гэртээ хоноё гэж бодохоор нөгөө төлөвлөгөө биелүүлж чадахгүй нь гэж бодохоор гараад явчихдаг байсан.
- Цагаан нуурт өглөө эрт гараад орой орж ирдэг байсан. Бензины Цистерн барьдаг байхдаа. /wife/
- Тийм. Төлөвлөгөө гэж тийм шахуу байсан. Одоогийн залуучууд болохоор та нар дарлагдаж байсан, боолчлогдож байсан, эрх мэдэлгүй байсан гэдэг. Бид нар тэр үед хамгийн жаргалтай амьдарч байсан гэж хэлдэг. Зовж байсан гэж боддогүй. Харин ч жаргалтай байсан.
- Бид нар маш их ажил хийж байсан. Их сайн ажил хийж байсан учраас бид нарын бие эрүүл тэгээд өндөр наслаж байна. Хөдөлгөөн сайтай, өдөр шөнөгүй явна, нойр хоолгүй. /wife/
- **Interpreter:** кроме планы государства, он составлял личный план. И дома он ночевал очень редко. Он говорит, что в то время мы жили очень хорошо. Много работали, поэтому у нас есть очень крепкое здоровье и так долго живём. Сейчас некоторые молодые люди говорят, - в то время вы очень плохо жили, вам не было свободы. Но он говорит, мы жили очень хорошо.
- *А вот он помнит, как потом происходила приватизация, вот там, где он работал? Что с машинами стало? Куда они пошли? Кому они достались? Достался ли ему что-то при приватизации?*
- Тэгээд хувьчлал болсон ш дээ, ардчилан хувьсгал гараад. Тэр үеэр та хувьчлалд юу авсан бэ, машин аа авсан уу?

- Хувьчлалд 90-н оноос 90 он тэрнээс урд гарсан хүмүүс юу ч аваагүй. Машин ч аваагүй, тэр байгууллагаас ер нь юу ч аваагүй гарч байсан.
- Та одоо тэгээд юу ч аваагүй юм уу?
- Би одоо юу ч аваагүй. Шинээр ажилд орсон залуучууд юм авсан болохоос урьд нь өч төчнөөн жил ажиллаж байсан, 40, 50-н жил ажилласан, 20, 30-н жил ажилласан улсуудыг нас чинь болсон гээд тэтгэвэрт гаргаж байсан. 55 нас хүрээд тэтгэвэрт гарч байсан. Тэгээд хувьчлал гэдэг юм хэлэлцэгдэж байсан болохоос юм тараагаагүй. Тэгээд бид нар гарсан. Одоо миний үеийн хүн байдаг. Одоо бид нар хөрөнгө машин байхгүй. Тэгээд авах гэхээр хүч хүрдэггүй. Тэгээд сүүлд үлдсэн улсууд бол бага ажил хийгээд машин тэрэг аваад гарсан байдаг.
- **Interpreter:** Он не мог взять машину себе. Потому что люди, которые работали перед 90-ым годом, стали пенсионерами. Им ничего не дали и они сидели на пенсии. Те люди, которые только что устроились на работу в начале 90-ого года, в конце 80-х они мало работали и во время привитизации взяли машину и некоторые вещи из учреждения.
- *А начальники?*
- Тэр үеийн дарга нар юм авч чадсан юм бол уу?
- Түрүүн гарсан нас ахисан дарга юу ч авч чадаагүй. Ер нь ихэнх хэсэг нь ардчилалын үеэр нас барсан юм ш дээ, тэр үеэр. Нөгөө их олон жил ажилласан улсуудыг гэв гэнэт буулгаад хаячихсан. Намын төв хороог татан буулгаад, сайхан ажилласан байгууллагын дарга, сайхан ажилласан намын дарга, сайхан ажилласан нэгдлийн даргуудыг чинь цуг нас барсан. Харвах нь харваад, элгээр нас барсан. Тэд нар элэг гэдэг чинь их хямралаас болдог гэсэн ш дээ... шоконд ороод цуг явсан ш даа, хөгшин улсууд болбол одоо ерөөсөө. Тэр үед их хэцүү үе байсан ш дээ.
- Би тэр ажлаа сайхан хийж байгаад хүмүүсийг гэнэт тэтгэвэрт гаргалаа гээд нэг өдөр тушаал уншаад л гаргачих дээр. Би нэг надыг юу яасан байхгүй юу тэтгэвэрт гаргаад, маргааш нь би ингээд гэрээ цэвэрлээд сууж байсан чинь 8 цагийн ажлын дуудлага нээх гоё хөгжим дуугардаг байсан чинь, тэр нөгөө ажлын дуудлагын хөгжим дуугарсан чинь би зүгээр нүдний нулимс гэртээ асгарч байсан юм чинь. Бид нар чинь тэгэж байсан. Бид нар чинь 4 хүүхэдтэй бол ерөөсөө нас хамаагүй ш дээ,

хамаагүй гаргадаг байсан. Тэтгэврээ авч чадсан ч хүн байна, авч чадаагүй ч хүн байна. /wife/

- Огцом ажилгүй болсон. Тэр чинь ингэсэн ш дээ, таныг одоо тэтгэврт чинь гаргана гээд.. тэр улсууд чинь одоо таныг одоо тэтгэвэрт гарах боллоо гээд тэр хүнд урамшуулал өгөөд л ингэж тэтгэврт гаргах гэж байтал, нөгөө ардчилал гарч ирэхээр, чиний ажлыг би авнаа гээд. Зүгээр нэг сайн ажилладаг дарга байхад зүгээр нэг доод ажилтан ажлыг чинь би авдаг гээд конторынх нь үүдэн дээр цагаан ор тавьчихаад ажилд нь оруулдаггүй, өрөө рүү нь гишгүүлдэггүй л байсан, тэгж л харвалт авч байсан юм. Тийм муухай зэрлэгээр авсан ш дээ.. энэ албан газрын дарга нарын ажлыг авах болбол. Манай тээврийн байгууллагад бол баазын даргын ажлыг чинь би авнаа гээд хамгийн танхай жолооч болчихсон, ашиглалтын даргыг ашиглалтын чинь ажлыг би авнаа гээд хамгийн танхай жолооч бас столон дээр нь завилаад суучихсан байсан ш дээ. Ийм маягаар хүчээр авч байсан ш дээ. Тэр чинь одоо яах ч арга байхгүй, нөгөөдүүл чинь ажил хийлгэдэггүй, тийм танхайчууд чинь хүчээр ажил авч байна гээд орчих дээр яах ч арга байхгүй бүх юм чинь хаягдаад ирсэн. Миний тэтгэврийн тушаал гарсан, тэгээд тэтгэврээ тогтоолгохоор нягтлан ч ажил хийдэг хүн байхгүй, шинэ хүмүүс орсон учраас мэддэг ч хүн байхгүй. 2, 3 сар тэтгэвргүй явж байж арай хийж хөөцөлдөж байж, тэтгэврээ тогтоолгосон. Нөгөө бүх улсууд чинь хамаг юм эзлээд авчихсан. Тэгсэн мөртлөө ажлаа хийдэг ч хүн байхгүй. Тийм болсон юм ш дээ. Тэр хүмүүс чинь бид нарын олж бүрдүүлсэн одоо тэр их улсын хөрөнгө яг хэдхэн хүний гараар л дууссан ш дээ. Одоо энэ том том компаний эзэд бүгд цуг тэрүүгээр баяжсан. Тэр үеийн баяжиж байсан хүмүүс чинь хөдөлмөр бага хийчихээд зоригтой танхай улсууд л баяжсан шүү дээ, тэр байгууллагын бүх юмнуудыг ашиглаад. Оросын бүх юмнуудыг ашиглаад, орос цэргүүдийг хөөж гаргачихаад, байрь байшин бүх юмнуудыг бүгдийг тийм л улсууд авсан ш дээ.
- Манай энэ хавьд оросууд байсан ш дээ. Тэд нарыг чинь нэг өдөр л ирээд шууд хөөгөөд, аягатай хоол нь бүлээн байсан гэж байгаа ш дээ. Тэгээд тэд нар чинь байгаа хувцастайгаа шууд гарсан. Тэгээд үлдсэн бүрэн тавилга, бүх хувцастай өрөөнд өөрсдөө ороод суучихсан. Мэддэг хүмүүс нь аав ээж, ах дүү нараа дуудаад оруулаад авчихсан. /wife/

- Одоо Улаанбаатарын тэр их том том газруудыг чинь одоо тэр яг хэлэлцээтэй. За орос цэргийг одоо гаргах гэж байна. Тэр байр өнөөдөр султгах гэж байна шүү. Гэтэл аав хүү хоёр ч байдаг юм уу, ах дүү төрөл садан ч байдаг юм уу нэг нэг байр эзэлдэг. Нөгөө улсуудыг чинь хөөгөөд л гарахтал шууд зөрөөд л ордог байсан. Нөгөө айлын бүх юм юу л байна тэр чигээрээ л үлдсэн байдаг. Зарим нь хоолоо хийчхээд хоолоо идэж чадаагүй хоол нь халуунаараа байсан гэж байгаа юм. Тэгээд тэр байр авсан нэг хөгшин надад хэлж байсан. Манай хүү нэг надыг дагуулж харайлгаж байгаад энд та нэг ороод суужээ гээд нэг байр луу оруулаад суужээ гээд нэг байр луу оруулчихаад, өөрөө яваад өгсөн. Тэгсэн чинь хөөрхий нэг хүүхэдтэй авгай нөхөр хоёрын байр байсан байна лээ. Хоёр том хүний хоол, нэг хүүхдийн хоол халуунаараа идэж чадаагүй хөөгдөөд гарчихсан. Тэгээд хоол нь халуунаараа л байгаад байдаг, гаднаас эзэн нь орж ирдэггүй. Гэтэл хүү нь орж ирээд Та одоо хоол идэхгүй юу хийж сууж байгаа юм, наад хоолыг нь ид гэж хэлсэн. Би өрөвдөөд, хоолыг нь идээд тэгээд байрны эзэн боллоо гэж хэлж байсан. Тийм маягаар л хувьчлал явагдаж байсан, энэ албан газрууд чинь бүгд тийм маягаар л авч байсан.
- **Interpreter:** В то время привитизации самые плохие шофёры хотели взять должность директора или начальника. Им сказали, что вы уходите на пенсию, мы будем работать вместо вас, и сидели на столах. Сразу после этой информации очень много старших начальников умерли из-за плохого отношения. Привитизация очень не правильно прошла. Некоторые люди, которые знали об этом, сами взяли, большинство молодые люди. Старшие люди, которые работали и способствовали для развития учреждения, ничего не получили. Он тоже ничего не взял. А молодые люди, которые мало работали и почти хулиганствовали, они почти взяли всё.
- *Когда они пришли... фактически то, что он описывает, физическая собственность, да... тогда вот эти пожилые люди, начальники которые много работали, они могли какую-то милицию пойти, как-то на них воздействовать можно было или только чисто силой решался вопрос?*

- Он говорил, что почти каждое учреждение не знали, что делать. Поэтому всё оставляли.
- Тэр үед өвөө дураараа аашилж байгаа хүмүүсийг цагдаад хэлж болоогүй юм уу?
- Энэ ардчилал гэдэг чинь эхэлж гарч ирэхдээ хуучин Төв хороо, Сайд нарын зөвлөлийнхэн хэн ч бай дуугарах эрх байхгүй байсан. Битгий захиргаадаад бай гээд ардчиллынхны өмнөөс дуугарах эрхгүй байсан. Тэгээд Хянан шалгах хороо байсныг татан буулгаад хаячихсан. Цагдаа нарын эрх үүргийг хориод, хүчиндүүлээд хаячихсан байхгүй юу. Тэгээд бүх юм чинь дураараа болчихсон байхгүй юу.
- **Interpreter:** эти делегаты демократизации пришли сюда и сказали всем руководителям аймака что не надо указывать людям что делать и не дал им право что -нибудь делать. Поэтому люди посвоему там вели себя. Сначала демократизация очень не порядочно была.
- Тэгээд тэр Төв хороо, Засгийн газрыг тийм маягаар буулгаж авсан ш дээ. Тэгээд өлсгөлөн зарлаад, талбай дээр хүмүүс өлсгөлөн зарлаад байхаар чинь яах ч аргагүй, тэд нарыг хамгаалахын тулд цуг ажлаа өгөөд явсан. Аймгууд ч гэсэн адилхан, бас л тийм маягаар. Хүчээр, ер нь бүх юм хүчээр авсан ш дээ. За яахав чи томилогдоод ирэв үү, за чи миний ажлыг ав гээд өгсөн. Ямар дарга байхгүй энэ аймгуудад бол. Нэг л танхай улсууд. Ардчилалаас за та нар тэгээд суучихаараа гээд л, тэр үед л ардчилалд орох хүн байна уу гээд санал аваад, нэр бичээд яваад байсан байхгүй юу. Би оръё, оръё гэснийг нь. За тэр байгууллагын даргын ажлыг би авнаа гээд суучих, би ашиглалтыг нь авьяа гээд суучих, би няравыг нь авьяа гээд суучих гээд л ингээд бүх юманд нь эзэн болоод суучих гээд. Ингэж хүчээр авсанаар олон настай дарга нарт сэтгэлийн хүнд цохилт, дарамтанд орсон. Тэгээд энэ улсууд чинь их нас барсан даа. Харвасан, элгэний хямралаар их олон хүн үхсэн. Ер нь дандаа настай дарга нар элэгний хямралаар цуг явсан. Одоо хуучин нэгдлийн дарга байсан Минжүүр гэдэг хөгшин л байдаг юм, бусад нь байхгүй дээ. Ер нь сайхан сайхан дарга нар цуг яваад өгсөн дөө. Албан газрын хуучин дарга нар ч гэсэн мөн адилхан.

- **Interpreter:** В начале демократизаций они почти насильственно взяли должность начальников. Некоторые люди пришли, зарегистрировали, что кто стать членом демократий. И написали их имена. И сказали им, что ты будешь директором этого учреждения, ты будешь бухгалтером и так далее. Таким образом, они велели делать это им. Они пришли сюда и сразу выгоняли старых директоров. Из-за этого у старых директоров были большой шок и они внезапно умерли.
- *То есть, те, кто пришёл выгонять старых директоров, им сказали пойти, да? Им сказал кто? Демократическая партия или новое правительство, или кто им сказал пойти выгонять старых директоров?*
- Тэгээд нөгөө тэр одоо хүмүүсийг хэн тэгэж чи тэр юмны дарга, чи тэгээр гэж хэлсэн юм бол?
- Ардчилал гарч ирж байхад, тэр урьд нь бас хэд гурван хүнтэй хэлэлцсэн юм байна лээ ш дээ. Ардчилал гэж нэг ийм юм гарна, хувьчлал гэж ийм юм явагдана гэж нууцаар. Тэгээд л тэр улсууд чинь дээрээс нэг тиймэрхүү чиг өгсөн юм шиг байгаа юм. Та нар ингээд дайраад юм эзэмшээд авах юм бол, хэн ч хөөцөлдөх юм байхгүй, та нарын л зол болно. Та нар тэр бүх ажлыг хүчээр ав л гэж ингэж хэлсэн шиг ... Би ер нь зүгээр тээвэрт яваад, Булганд арван хэдэн хоног яваад хүрээд ирсэн, тэгэхэд л баахан залуучууд доогуур дээгүүр хараад үзээд байх юм, машин ирээд зогсох дээр зэрэг. Чи яаж байгаа юм гэхээр, таныг хоёр хоног хүлээлээ, чи яах гэж байгаа юм, таныг машиныг авнаа. Би яах юм бэ гэсэн чинь, таны амралтын тушаал гарсан. Тэгээд л ороод ирэх дээр зэрэг машины бүх бичиг баримтыг механик аваад бариад зогсчихсон, таны машиныг энэ залуу авхаар болсон, та машины хүлээлгэж өг гэсэн. Шууд гэртээ ирээгүй тэгээд машинаа хүлээлгээд өгчихсөн. Тэгээд тэр машиныг дор нь хүлээгээд авчихсан. Миний хөнжил гудас, жижиг хэрэгсэл, бүх юм машинд дотор олон жил явсан юм чинь байлгүй яахав. Тэрийгээ тэр жолоочоос гуйж байж арай гэж гэртээ авчирхсан. Гуйж байж юмаа авъяа, бүх хувцасаа авъяа гээд гуйж байж арай хийж машинаа гадна авчирч байж юмнуудаа авч байж билээ. Ер нь тиймэрхүү маягаар хандсан юм ш дээ, энэ ардчилал гарч ирээд. Их эвгүй. Нэг хэсэг ажил хийдэг хүн байхгүй. Одоо бол төлөвлөгөө гэж юм гэж байхгүй,

хүний эрх гэдгийг өндөрт тавьчихсан. Одоо ч гэсэн та нар хар 8 цагтаа ороод ажиллаж байгаа хүн бараг байхгүй. Доод тушаалын улсууд чинь ерөөсөө ажил хийж чадаж байгаа хүн байхгүй, нэг л салаалсан л юм байна ш дээ. Сайхан юм юу болж байна гэхээр яахав мал жаахан өсөж байна. Малчдын ашгаар мал өсөж байгаа. Газар тариалан гэдэг юм уначихсан байсан чинь, Баяр гэдэг хүн гарч ирээд хөдөө аж ахуйг хөгжүүлээд овоо хуучин хэвэнд нь оруулж байна. Бусад газар одоо тийм юм байхгүй. Тээврийн байгууллага тэгээд бид нараас хойш машинуудыг нь эзэн эзэнд нь өгөөд гаргачихсан. Тэгээд тэр одоо энэ аймагт хоёрт ордог хөрөнгөтэй байгууллага байсан. Барилга анги гэж нэгдүгээрт хамгийн их хөрөнгөтэй, тээврийн бааз хамгийн их хоёрт нь орж байсан. Тэр хэдхэн хүн хувьдаа аваад л, тэр их хөрөнгийг Хятадад өгөөд, заримыг нь зараад устгаад л тэгээд л өнгөрсөн дөө. Тэгээд бид нар шиг олон жил ажилласан хүн юу ч юм авч чадаагүй гарсан. Харин одоо тэтгэвэр их бага авдаг байсан, тэгээд л жил жил жилд жаахан нэмэгдсээр байгаад одоо...нөгөө тэтгэвэрийг тэнцвэртэй болгоно гээд байгаа боловч тэнцвэртэй болж чадахгүй байна. 92-93 онд тэтгэвэрт гарч байгаа улсууд чинь 400-500 төгрөгөөр гарч байсан. Бид нар чинь 280 төгрөгөөр тэтгэвэрт гарч байлаа. 280 төгрөг чинь явсаар байгаад 2000 болоод, дараа нь 22000 мянга болсон. 22000 мянган төгрөгтэй тэтгэвэртэй олон жил явсан даа. Тэгж байгаад сүүлд нь нэмэгдсээр байгаад одоо 300-гаад мянган төгрөгний тэтгэвэртэй болсон.

- **Interpreter:** Ну, он не помнит хорошо, что происходило, но некоторые люди, которые предварительно взяли информацию из Улаанбаатара, скоро будет привитизация и будете готовы к этому, планируете, что вы хотите взять во время привитизации и возьмите вещи. И он один раз 10 дней работал в Булган сомоне. Когда он приехал из командировки из Булган сомона, один молодой парень пришёл посмотрел на его машину и сказал ему, - “это моя машина сейчас и выйди, пожалуйста”. Он пошёл в свой оффис, и его директор сообщил ему, что нужно передать все документы его машины новому шофёру, - “и ты можешь уходить на пенсию”. И даже он с дальней дороги не мог поехать домой на своей машине. Потом он попросил этого парня, чтобы взять свой личные вещи.

Так он взял своё одеяло и другие вещи. Таким образом, от него взяли его машину.

- *И его ещё спросите, как на его предприятие происходила приватизация?*
- **Interpreter:** молодой директор взял эту автобазу. Это очень большое учреждение. Второе место занимает в аймаке по имуществу. И взял это парень и продал половину этой автобазы китайцам и остальные продал в других аймаках, другим бизнесменам. И таким образом исчезло это предприятие.
- *А вот... его жена, она работала на швейном предприятии, на какой-то фабрике. Как у них проходила приватизация?*
- Эмээ таны ажиллаж байсан оёдлын газар тэр ахуй үйлчилгээний комбинат яаж хувьчлагдсан бэ?
- Манай ахуй үйлчилгээний хувьд чинь ерөөсөө шууд... нэг манай хуучин дарга гарсан байхгүй юу, нөгөө хэлмэгдэл гэж хэлхээс яахав. Тэр үед манайх чинь бараг 15, 16 жил ажилласан нэг настай хөгшин дарга байсан. Тэгсэн энэ Намын Хорооноос Хөхөө гэдэг хүнийг томилсон байдаг. Тэр ирээд л ерөөсөө хуучин ажилчдыг бүгдийг халаад л. Хуучин ажилчид бид чинь нэг ширхэг утас ч аваагүй, машин зашин ч аваагүй. Бид нар бүх хөрөнгөө мэддэг, олон жил ажилласан биднийг бүгдийг нь халчихаад дараа нь ирсэн залуучууд юугаа мэддэг юм бэ, хаана юу байгааг юу ч мэдэхгүй шүү дээ. Тэгээд нөгөөдүүлийг авчихаад, тэгээд энэ бүх юм, үйлдвэрийн хөрөнгийг 15-20 хүн хувааж авсан ш дээ. Тэр дарга чинь ирээд шууд хувааж авсан. Тэр найз нөхөд, хамаатан садангууд ирээд л шууд хувааж авсан. /wife/
- Тэгээд ер нь тэр ардчилалд гарсан хүмүүс л тэгэж байгаа юм л даа.
- Далимдуудаад л одоо... монголын хөрөнгө чинь тэгээд сүйрээд дууссан ш даа. Хөдөө болбол тэр малын хашаа саравч, тэгээд ерөөсөө байх юм байхгүй... Тэрнээс чинь одоо нөгөөх жинхэнэ овсгоотой улсууд нь л хувьчилж аваад баяжаад байгаа юм. /wife/
- 55 хүрсэн хүнийг нас чинь болчихжээ гэж, 55 нас хүрээгүй 22 жил ажилласан хүнийг ажилласан жил чинь гүйцчихжээ гэж хуучин ажиллаж байсан хүнийг хоёр янзаар халсан байхгүй юу. Зүгээр шинэ хүмүүс энэ

байгууллагыг ямар хөрөнгөтэй юм, юу байдгийг ч мэдэхгүй. 70-оноос урагш бүх архивыг устгасан байдаг. Тэтгэврээ дахин тогтоолгохгоод 70-оноос урагш юмаа хайх гэхээр хайх юм байхгүй, юу ч байхгүй. Устгадаг нь яаж байгаа юм гэхлээр, төчнөөн хөрөнгө байж гэдгийг мэдэгдүүлэхгүй гээд устгасан. Тэрнийг чинь хөөцөлддөг хүн байхгүй, мэддэг хүн байхгүй. Тэгээд одоо заримыг нь хөөцөлдөхөөр хөндий байшингууд байдаг. Дотроо ямар хөрөнгөтэй байсан ч бүү мэд, мэдэх хүн байхгүй. Заримыг нь нэг нэгэндээ балансаар шилжүүлсэн байна гэж байгаа юм л даа.

- **Interpreter:** новый директор пришёл на швейном фабрике, который звал Хөхөө. Он поменял все старых работников на новых и это была его друзья и родственники. Они ничего не знали, как работать на швейном машине. Она с собой ничего не взяла тоже. Они потом разделяли всё имущество фабрики на себе, и всё. И ещё всё архивы до 70-ого года они исчезли.
- *До 70-го года? И только 70-ого и 80-ого есть? А почему надо было уничтожить эти архивы?*
- Потому что они хотели чтобы люди не знали об этом. Потому что они сами взяли все государственную имуществу.
- *То есть тех, кто в 70-ых годах, да? А вот этот новый директор, звали как, Хөхөө, да? Что он был за человек, сколько ему тогда было лет, был ли он членом МНРП, что он заканчивал, откуда он взялся?*
- Эмээ тэр Хөхөө гэдэг дарга ямар хэдэн настай, хаана сургууль төгссөн, ямар боловсролтой хүн байсан бэ?
- Их сургууль төгсөөд тэр хүн Намын хороонд л ирсэн юм билээ. Дээр үед чинь одоо сургууль төгссөн улсуудыг албан газар хувиарлаад хувиарлаад өгчихдөг байсан. Намын хороонд дээгүүр нэг дарга төвлөлөөд өгсөн юм билээ. Тэгэхэд чинь бүх юмыг дарга нар мэддэг байна лээ ш дээ. Намын хорооноос шууд ахуй үйлчилгээн дээр томилоод. Том дарга нь 55 хүрсэн юмуу яасан юм, тэгээд тэтгэврт гаргах нэрийдлээр тэгээд л 27-28-тай залуу байсан байх. Одоо тэр хүн нас барсан л даа. Тэр хүн маш их хөрөнгөтэй үлдсэн гэж байгаа юм. /wife/

- Тэр хүнийг томилсон хүн тухайн үедээ ардчилалыг дэмждэг хүмүүс байсан уу?
- Тэгэлгүй яахав дээ. 91, 92-оноос хойш чинь Намын хороо ч гэсэн, захиргаа ч адилхан цуг ардчилалын хүмүүс болсон байхгүй юу. Хуучин ажилтнуудыг цуг ажилгүй болж гараад л, яаж байгаа юм гэхлээр та 55 нас хүрсэн шүү тэтгэвэртээ гар гээд, ажилсан жил чинь гүйцсэн байна гээд 40 хэдтэй байсан ч гаргадаг байсан.
- Дөрвөн хүүхэдтэй болсон эмэгтэйчүүдийн нас хамаагүй, дөрвөн хүүхэдтэй л бол залуу залуу сайхан хүүхнүүд бүгдээрээ гарсан байдаг. Тэгээд тэд нар чинь одоо тэтгэврээ зарим нь олж авч чадахгүй, зарим нь одоо хүртэл тэтгэврээ авч чадахгүй нас нь хүрэхгүй. Хэлмэгдсэн юм их байна шүү.
- Тээврийн жолооч гэхэд бид нар төлөвлөгөөтэй нормтой байхдаа хоёрхон хоногийн нормтой байлаа. Ухаан нь Цагаан нуур гэхэд 280 км байдаг бол түүнд хоёрхон өдрийн норм өгдөг. Ардчилал гарснаас хойш цистернийн жолооч нар, одоо ганц нэг тээвэр хийдэг газар 5-6 хоног болж ирж байна. Дураараа, өөрийн дур. Хэд хоноод ч ирсэн болно. Бид нар бол хугацаатай.
- Их дураараа, хяналт шалгалт байхгүй. Захиргаадалт хатуу. Тэдэн цагт явсан, тэдэн цагт ирэх ёстой гээд товчоон дээр байдаг. Өглөө явахдаа бүртгүүлээд, ирээд бүртгүүлдэг. /wife/
- Тээврийн товчоо гэж сайхан бүртгэдэг газар байлаа. Машин ухаандаа тэр машин тийшээ явлаа, тэр машин Цагаан нуур явлаа гээд бүртгэдэг. Буцаж ирээд бүртгүүлээд л ордог. Тэр үед чинь хулгай байдаггүй байхгүй юу. Тэр бүгдийг татан буулгачихаар хүн бүгд машинтай болоод ирэхээр, бүртгэсэн юм байхгүй болохоор, хулгай хийгээд л, мал хөөгөөд, есөн шидийн юм хүн алаад л...ингээд явж байгаа чинь бүртгэлгүй байгаагийн шинж шүү дээ. Тийм бүртгэлтэй байсан бол тэр хүн тэгсэн байнаа гээд л бариад л авна шүү дээ. Тийм юм байхгүй болохоор чинь дуртай нэг нь орж гараад л ингээд явж байна шүү дээ. Одоо тэр чинь хэрэг зөрчил гардаг, хулгай гардаг... Одоо чинь сүүлийн үед өөрийн эрх гэдэг юмаар цагаа барьж цагтаа гардаг, цагаа барьж цагтаа ирдэг хүн байхгүй шүү дээ.

- Одоо ингээд нэг ажил гараад, эрүүл мэндийн дэвтэр дээр ч юмуу, ямарваа нэг юман дээр тамаг даруулж, гарын үсэг зуруулах шаардлага гарвал ерөөсөө контор очоод онгойдог газар байхгүй. Өглөө нэг бүртгүүлээд гардаг. Үдээс нэг цагаас хойш ямарч албан хаагч байхгүй. Ер нь ажил хийдэг хүн байхгүй. Хариуцлага юм гэж ерөөсөө байхгүй. /wife/
- 90-оноос өмнө чинь бүх юм диктатуртай, бүх юм хариуцлагатай байна лаа. Гудамжинд шээдэг хүн байхгүй байсан. Одоо бол хүн бүхэн хашааны ёроол руу шээж байна, энэ орцон дотор хүртэл шээж байна шүү дээ. Тийм л болчихлоо. Сайхан юм сайхан газраа сайхан болж л байдаг байх. Ардчилал гараад их хохиролд орсон ш дээ. Одоо би энэ их хурлын гишүүдэд, энэ улсуудад хэлдэг юм. Анх л эхэлж ардчилал гаргасан улсуудаасаа улсын хөрөнгө нэх гэж хэлдэг юм. Ухаан нь энэ сангийн аж ахуй гэдэг чинь ямар их том хөрөнгөтэй, ямар их олон трактор комбанитай тэр айл бол хөлбөрөх хөрөнгөтэй байсан ш тэй. Тэгэхэд чинь сайхан сайхан техникуудыг бүгдийг нь задлаад ачаад л Хятадад төмөрт өгөөд л дуусгасан. Одоо манай энэ байгууллага адилхан.
- Одоо манай энд Цементний үйлдвэр байсан. Тэгээд цугий нь одоо төмөрт ачаад одоо зүгээр л балгас болсон. /wife/
- Одоо тэр улсуудаас дахиж хөрөнгөө нэх гэж байгаа юм. Бидний насан туршдаа зүтгэж байж хөгжүүлсэн хөгжил, Цэдэнбалын 40 жил удирдсан, 70 жил бидний хөгжүүлсэн бүх хөрөнгийг хэдхэн хүн танхай улсууд нураагаад, хуваагаад идчихсэн.
- Бидний үед чинь өвчтэй хүн бараг байхгүй байсан. Бүгд эрүүл байлаа. Нийгэм бол тэгшрээд их гоё, баян ядуу хүмүүсийн ялгаа байхгүй байсан. /wife/
- Дээр үед баян хоосны ялгаа байхгүй, ядуу хүн байгаагүй. Цуг дор дор ажилтай байсан. Цэргээс халагдсан хүнийг хүртэл томилолтоор байгууллагад ажилд оруулдаг байна лээ ш дээ. Сургууль төгссөн хүнийг хаана ямар газар орон тоо байна, тэр рүү нь томилоод явуулдаг байсан.
- Одоо чинь хоёр, гурван их сургууль төгссөн хүмүүс ч ажилгүй, ажил олдохгүй байна ш дээ. /wife/

- Хамгийн гол нь нөгөө сайхан хөгжсөн хөгжлөө устгаад, бүх үйлдвэр аж ахуйн газрыг бүх юмыг устгачихаар, зүгээр л сургууль төгссөн хүмүүс л ажилгүй яваад байхаас биш ажлын мөст гэж байхгүй байна.
- Хөгшчүүл маш их сэтгэл дундуур байгаа шүү. Сэтгэлийн мухарт бол шаналгаатай, энэ залуучууд яаж амьдарна аа. Иддэг хоолно хүртэл дандаа хортой болохгүй юм ирж байна. Тэгэхэд чинь ерөөсөө иддэг хоол бол хүнд нөлөөтэй юм байгаагүй шүү дээ тэр үед чинь. /wife/
- Зөвлөлтөөс өөр орноос юм авдаггүй байлаа. Одоо би дотроо боддог юм. Зөвлөлт орон шиг үнэнч, зөвлөлт орон шиг сайхан чанартай, үнэнч юм хийдэг газар байгаагүй. Манайд бол одоо Зөвлөлт орон ер нь ямар сайхан сэтгэлтэй хүмүүс байдаг юм гэж боддог. Манайханд өгч байгаа юм бол дээд зэргийн чанартай, ерөөсөө хуцас хунар бүгдээрээ. Одоо энэ Хятадаас ирж байгаа юм бол ямарч чанар байхгүй. Зөвлөлтийн юмнууд бол манай хоёр орны уур амьсгал адилхан болохоор хоол унд тэр бүх юм таардаг. Тэгээд одоо энэ Хятадын юмнуудаас бол өвчин их дэлгэрч байна. Тийм л болчихсон байгаа юм. Миний бодлоор бол зөвхөн хувь хүнд бодогдоход 80 хэдэн хохирол гарсан байдаг ш дээ. Одоо бидний ажиллаж байсан үеэс хойш дээ. Тэгээд би энэ их хурлынханд заримд нь хэлдэг юм. Та нар энэ ардчилалынхаас хөрөнгөө нэхээчээ. Дайнаас илүү хохирол гаргасан гэдэг. Замын тээвэр хийж байгаа улсууд бол тэр хүндээ бол сайхан болсон байна учир нь дураараа яваад ирсэн. Тэгээд та одоо хэд хоноод ирж байнаа гэхлээр хэд хоноод ирсэн ч яадаг юм, хүний эрх ш дээ гэж хэлж байх юм.
- Бид нар хөгшчүүд одоо энэ сайхан сайхан залуучууд бильярд тоглоод байж байх юм. Тэр их сайхан хүч хөдөлмөрийг нийгэмдээ зориулвал ямар сайхан байхав. Одоо тэгээд лам нар гээд л дандаа хүүхдүүд эрэгтэйчүүд. Лам нар ерөөсөө ямар хүртээлтэй юм бэ. Аюул болбол тэрийг хамгаалж чадахгүй. Одоо энэ салхи шуурга, энэ малын зуд ... ямарч нэмэр байхгүй, лам нар. Би одоо хөгшингүй учраас тэгэж хэлэхээр чамд эвгүй л байхалдаа. Шүтлэггүй юм байна гээд. Тэгээд цугларч байгаа залуучууд, лам нарт дотроо их эмзэглэж байдаг. Зүгээр ажилгүй ингээд л үнэн худал нь мэдэгдэхгүй зүгээр юм уншчихгаад монголынхоо нийгмийн юмыг идчихгээд суугаад бие амар байж байдаг. Бильярд тоглоод өдөр хоногийнхоо хэдэн цаасыг аваад тоглоомоор байж байдаг.

Энэ их хүч хөдөлмөрийг нийгэмдээ зориулвал ямар сайхан болох болвоо. Тэгээд тэрийг бодоод эмзэглэдэг. Яанаа энэ сайхан залуучуудын хүч хөдөлмөрийг, яанаа энэ их лам нар болж байгаа хүүхдүүд хайран юм гээд л.. Монголдоо нийгэмдээ ямарч нэмэр байхгүй. Зүгээр л баахан сайхан залуучууд.. Тэд ажил хийх, зүтгэдэг хүн алга байна шүү. **/wife/**

- Манайд нэг хуулийн сургууль төгссөн сайхан залуу ажил байхгүй. Одоо бүр унтсаар байгаад сурчихсан. Ажил хийе гэсэн ч чадахгүй. Одоо бүх залуучууд тийм болчихсон.
- Шөнө нь нөгөө тоглоомын газар тоглож тоглочихоод үрээр ирж өдөржин унтаад л. Хүүхдээ муу хэлж байгаад намайг уучлаарай. Тийм жишээтэй байна, Тэгээд эмээ өвөөгөөс мөнгө татаад л. Нийгэм тийм болчихсон байна. Хэцүү байгаа биз. Тэтгэврийн хөгшчүүд хүүхдүүдээ тэжээж байна шүү дээ. Манайд хоёр жолооч залуу байна, нэг ажилчин залуу байна, хоёр наймачин охин байна. Цөмөөрөө ажилтай л даа. Тэгэхдээ бид нарын санаанд хүрч чадахгүй байна тэд нар . Бид нар чинь унтах нойргүй, идэх хоолгүй хөдөлмөрлөж, зүтгэж сурсан улсууд, мах цусанд шингэсэн улсууд. Тэгээд бас хүүхдүүд сэтгэлд хүрэхгүй байна. **/wife/**
- Дээр үед чинь одоо ардчилал гарч ирээгүй байхад чинь ганцхан Зөвлөлтөөс машинаа авна, бүх бараагаа Зөвлөлтөөс авна. Машин бол хуучин ийм их олон машин байгаагүй, зөвхөн хэрэгцээнийхээ машиныг албан газрууд авдаг байсан. Одоо бол энэ машин хүний хэрэгцээ гээд солонгосын баахан хог оруулаад ирчихсэн, шоргоолж шиг болгоод хаячихсан. Одоо энэ агаар бохирдож байна. Одоо энэ түмэн машин байхад, хичнээн ч уурын зуухаа өөрчлөөд ч мөн л утаа хэвээрээ л байна ш дээ.
- Хааяа нэг хүүхдүүд дээр хот орхоор чинь хамар цээж гашуу оргиж байгаа ш дээ. Пөөх та нар яаж амьдарч байна вэ гэхлээр та тэгэж үнэртэж байна уу танд гэж байгаа юм. Хөдөөний хүн бол мэдэлгүй яахав. Хот дотор бол мэдэх юм байхгүй. **/wife/**
- Онгоцоноос бугаад машин тэрэгтэй энх тайвны гүүрээр явж байхад хоёр нүд, хоолой хорсоод ирдэг ш дээ. Зуны цагт шүү дээ.

- Одоо тэр энэ жолооч нарын талаас ярихад, одоо энэ жолооны сургуулиуд өөрсдөө юу ч мэдэхгүй улсууд. Жаахан дүрэм заана, онолын талаар юу ч мэдэхгүй, юу ч заахгүй. Жолооны сургуульд суучихаад, жолооны үнэмлэхээ авчихсан нэг хүүхэнийг би хараад миний инээд хүрээд ёстой сонин санагдаж байсан. Үнэмлэхээ авчихсан жолооч машиныхаа капотоо сөхчихсөн байхад очоод тэгээд нөгөө дэх нь карубетор гээд хэлээд байдаг нь аль нь юм, тэр байна гэхээр, мотор гэдэг нь аль нь юм гэх юм. Тийм жолооч байх уу. Бас энэ энд сонин юм болсон. Нэг эмэгтэй жолооч машинаа траншейны бөөрөнхий таглаан дээр гараад явчихсан чинь траншейны таглаа нь хажуу тийшээ уначихсан юм байна лээ л дээ. Тэгсэн чинь хоёр залууг дуудаад энэ төмрийг миний машины ард хийгээд өгчих гэсэн юм байна лээ л даа. Гэртээ очоод нөхөртөө би баларсаан. Машинаа эвдэлчихлээ, нэг юман дээр гараад явчихсан нэг том төмөр унаад. Тэгээд нөхөр нь харчихаад, өө энэ чинь траншейны таг байна ш дээ гэж байгаа юм.
- *Что за смешная история, я не поняла?*
- **Interpreter:** он очень не доволен сегодняшним шофёром. Потому что не качественно подготавливает в автошколе новых водителей. Даже не знает, где находится мотор машины. Современные шофёры. Один раз одна женщина-шофёр ехала на своей машине. И она на траншее съехала. В это время круглая крышка траншеи упала на другое место. И во время этого она очень беспокоилась, что это железо упало от её машины. И спросила двух мальчиков поднимать эти железу на её машину. И вернулась домой и сказала мужу, что я сломала машину. Но когда её муж смотрел это, он сказал: “Ты тащила крышку траншеи”.
- Одоо тийм чанаргүй болсон. 92 онд би хот орчихсон явж байсан 3 оюутан ярьж байна. Чи ямар лут толгойтой болчихсон юм бэ. Чамайг 3 сургуульд сурч байна гэж сонссон. Нэгийг нь би хаячихсан. Хоёрт нь сурч байгаа би гэв. Чи тэгээд хоёр сургуульд яаж сурч байна вэ гэсэн чинь өглөө нэгэнд нь үзэгдээд л, үдээс хойш нөгөөд нь үзэгдээд. Мөнгөө өгчихсөн юм чинь дипломыг нь авч л таараа гэдэг. Тэгэж байгаа хүн юу сурах вэ дээ.

- **Interpreter:** когда он 92 году был в Улаанбаатаре, 3 студенты разговаривают между собой. Один говорит, что он слышал, ты учишься одновременно в 3-х университетах. Другой отвечает, что он бросил одну, сейчас он учиться в 2-х университете. Какой ты умный, как ты успеешь делать всё одновременно. Он отвечает, что он утром зайдёт на лекцию одного университета, а после полудня в другом университете, и таким образом он продолжает учиться. “Я заплатил деньги на учёбу, всё равно в конце концов я получу диплом”. Они очень не довольны в демократизации. Потому что демократическая партия почти бросили людей. Сам себе взял всё имущество государства и при этом безработица возникла, поэтому они очень не довольны.
- *А что она рассказала, когда спросила на счёт “Кукушки” “Хөхөө” ?
Что о нём рассказала?*
- **Interpreter:** Кто “Кукушку” назначил работать директором, то есть из какого учреждения, она не помнит. А потом люди, которые поддерживали демократизацию, решили его поставить директором этой фабрики. И он пришёл директором и сделал такие неправильные решения.
- А сколько ему было тогда ?
- **Interpreter:** 28
- **Он что... наверное, не разбирался в швейном деле?**
- **Interpreter:** Она не помнит, какая профессия у него была.
- Сонин сонин юм их байна аа. Хөгшчүүл болох ч юм хэлнэ, болохгүй ч юм хэлнэ. Зарчимтай, замбараатай нийгэмд өсч ингэж ажил хийж ингэж хөгширтлөө явсан хүмүүс чинь ингээд тэр болохгүй байнаа гээд дандаа шаналж явах юм. Уул нь тэгэх л ёстой байсан юм даа, ингэх л ёстой байсан юм даа гээд... /wife/
- Тэрнийг би яагаад хэлж байгаа юм гэхлээр тэгж сургууль төгссөн хүмүүс одоо энэ дарга нар бол ямар өөдтэй байх вэ дээ. Жинхэнэ чанартай төгсөөгүй улсууд болохоор ямар л өөдтэй байхав дээ гээд л бодоод байна.
- **Interpreter:** Он говорит, что таким образом большинство студентов не качественно окончивает университет и ничего делая, в конце концов они

получают диплом. И станет директором какого-нибудь учреждения. И такие люди не может быть хорошим директором, и так во всех сферах такие люди появятся, поэтому Монголия не может развиваться, поэтому он очень не доволен.

- ***Поблагодарите их, пожалуйста, что такой интересный рассказ, они так откровенно рассказали нам о своей жизни, свои мнения высказали, что это очень интересно и очень важно для нас.***
- За тэгээд та хоёрт маш их баярлалаа. Бид нарт маш их хэрэгтэй мэдээлэл илэн далангүй ярьж өглөө. Цаг зав гаргасанд баярлалаа.
- Бид нар ч гэсэн баяртай. Хөгшин хүмүүсийг ингэж тоогоод энд орж ирж сайхан ярилцлага авсанд чинь, маш их баяртай байна бид хоёр. /wife/
- **Interpreter:** Они тоже очень рады что разговаривали с ними.
- ***Я хочу сфотографировать их сейчас.***
- Чи аль аймгийн хүүхэд вэ?
- Би өөрөө Ховдын төвийн хүн. Манай өвөө аав болохоор Зандан багш гэж байсан. Тэр манай ээжийн аав. Би ач нь байгаа юм. Би одоо өөрөө Ховдын их сургуульд орос хэлний багш. Тэгээд энэ хүн ирээд.
- Энэ хүн хаанаас ирсэн хүн бэ?
- Энэ хүн Орос хүн. Тэгэхдээ Германы Хумбольдын их сургуульд ажиллаж байгаа, ардчилалын талаар түүхийн ухааны докторын зэрэгтэй хүн юм. Судалгаа явуулах гэж ирсэн юм гэнэ.
- Ардчилал гараад сайн юм ч болж байгаа байх, бас саар ч юм их болж байгаа байх. Одоо энэ их залуучуудыг гадаадад гаргаснаас болоод одоо хоёр сургууль төгсчихсэн хүүхэн нөхөр байхгүй. Чи одоо яагаад нөхөрт гарахгүй байгаа юм гэхээр эрчүүдийн сайхан нь цөм гадаадад гараад явчихсан, энд үлдсэн нь архи ууж тамхи татдаг хог шавхруу нь үлдчихсэн. Тийм хүмүүстэй бид яаж амьдрах вэ дээ гэх юм. Тэр бол одоо яаж байгаа бол, монгол орон чинь юу болох гэж байгаа юм бол энэ их олон хятад орж ирж байна.
- Харин тийм хятадууд орж ирээд их дураараа аашилж байна ш дээ.
- Одоо бүр хачин юм болж байна. Ер нь хятад эзлэх гэж байна, яваан даа. Хичнээн их газар авч байна. Ямар их хятадууд орж ирж байна. Багачууд хүүхдүүд цус өөрчлөгдөж байна. Тиймэрхүү юмнуудад эмээ нь шаналаад

байдаг юм. Ирээдүйд Хятадууд монголыг авах гэж зорилготой л орж ирж байна ш дээ. /wife/

- Ардчилал гарч ирсэнээс хойш хөдөөний хавар, өвөл, намар гээд гурван ээлжийн хашаатай л байсан ш дээ. Чи бол зах зухаас нь бас мэдэж л байгаа байх. Одоо тэр бүх хашаагий нь устгачихсан. Одоо энэ шуурганд мал урууд лаа барилаа гээд хэлцээд байдаг, тэр хамгаалах хашаагий нь устгачихсан юм чинь. Худаг гэдгийг чинь зөвхөн дээр нь байгаа модон барилгаар нь үнэлээд хувьчлаад зарчихсан, худагны үнэн нь газар доороо байхгүй юу. Тэгээд тэр газар доороо байгаа устай цэгийг олно гэдэг болбол хамгийн чухал юм нь тэнд байдаг байхгүй. Тэгээд тэрнийг чинь салгаад хаагуур нь салж гарч ирэх нүү, түүгээр салж гарч ирээд цаад талыг тэнд нь тэр чигт нь газарт нь гацаагаад хаячихсан. Дахиад тэрнийг гаргаж ирээд тэрний оронд өрөмдөж худаг гаргахын арга байхгүй. Өөрөөр хэлбэл, тэгээд нөгөө устай цэг гэдэг чинь ингээд нарийхан устай судал газрын хөрсөн доогуур, тэгэхэд энд нь ч хатгаад ч олдохгүй, тэнд нь ч хатгаад олдохгүй байхгүй юу. Ингээд бодохоор улсад зөндөө хохирол учраад байна. Одооны сүүлийн бага хүүхдүүд тийм ийм юмны цаадах наадахыг мэдэхгүй л дээ. Бидний үеийн хүмүүс жаахан дотор харамсал төрөөд байх юм. Жишээ нь эмнэлэг гэхэд чинь, хоногоор хязгаарлагдаггүй байлаа ш дээ. Хүний өвчнийг хэзээ л эдгэнэ үү тэр цагт нь гаргадаг байсан. Одоо бол ямар өвчтэй байсан 10 хоног, 5 төрлийн өвчтэй байсан бол 1-ийг эмчлээд л гаргадаг. Хоног чинь гүйцлээ гээд л гаргана. Цаад хүний өвчин даамжраад нас барна. Нас баралт ихдээд байх юм. Тийм тийм жишээтэй бүх юманд болчихоод байна. Сайхан юм болж байна гээд одоо хэлээд. Гадаад оронд хаа хамаагүй доншуучилж явдаг, гадаад оронд суудаг тэр нь их сайхан юм болж байх шиг байна. Би одоо 1987 оноос хойш хүн барьсан хүн. Одоо ч хүн барьдаг. Саяхан 3 хүн барьж гаргачихаад байна. Тэгэхэд эмнэлэг бол ерөөсөө хүний өвчний ганцхан талыг л барина, бусад нь надад хамаагүй гэдэг болчихсон ийм сонин юмнууд их байна даа. Энэ монголын цус гэдэг юмаа хамгаалахгүй л бол болохоо байлаа. Одоо залуучуудыг гадаадад гаргахгүй ш дээ. Одоо гадаадад сайхан мэргэжилтэй хүмүүсийг монголдоо ажиллуулаад, гаднаас хүч авахгүй байх хэрэгтэй. Энэ компаниуд гэж хэцүү хүмүүс

- байна, тэднүүд монголчууд залхуу, ажил хийдэггүй гэдэг нэрээр дандаа Хятадаас хүмүүс оруулж ирээд байна ш дээ.
- Хятадаас дандаа хог орж ирдэг гэнэ шүү. Сайхан ухаантай ажил хийдэг хятад ирдэггүй. Шорон оронд орсон, ажил хийдэггүй, одоо өр ширэнд баригдсан хүмүүс ирдэг гэж байна шүү. /wife/
 - Хятадад нөгөө илүүдэл хүүхэд гэж ярьдаг даа. Хятадуудад 2 хүүхэдтэй байх ёстой гэдэг. 3 дахь хүүхэдтэй нуучихдаг гэнэ. Тэр нь бүртгэлгүй болохоор монголд орж ирдэг гэж байна. Тийм яриа гарч байдаг.
 - Монголчуудын тун сайхан сайхан залуучууд одоо бүх шинжилгээ хийлгээд сайхан эрүүлчүүд нь гадагшаа явчихдаг. Өвчтэй зовлонтой нь энд үлдэж байна. Хайран юм гэдэг байхгүй юу. Тэнд очоод амьтны боол болно, дандаа муу хоол иднэ, тэгээд өвчтэй болоод орж ирнэ. Будаа ногоо иддэг хүмүүс монгол хоолоо идэхээр огиод л...мах шөлний үнэр авч чадахгүй. /wife/
 - Өөр одоо бид нараас асуух юм байна уу? Өөр сонирхсон зүйл байна уу гээд асуудаа.
 - **Interpreter:** они говорят слишком много. Потом я вам расскажу. Ещё есть вопросы?
 - *Думаю, что мы всё исчерпали. Очень хорошо они ответили на все вопросы. Большое спасибо и я хотела бы сфотографировать их сейчас.*
 - Одоо ч сонирхсон зүйл алгаа. Бүх сонирхсон зүйлээ асуучихлаа. Та хоёрын зургийг одоо авч болох уу гэнээ? Өө, тэр хувцас хунар зүгээрдээ эмээ...
 - **Interpreter:** можно
 - Энэ их бас сонин бэлгэдэлтэй зураг байгаа юм. Энэ манай бага охин. Энэ хоёр эгч, ах хоёрын хоёр хүүхэд байхгүй юу. Тэгэхэд жаахан охин байхдаа энэ хүүхдүүдийг хоёр талд нь тэвэрч байгаад зургаа авахуулсан байхгүй юу. Айлын авгай болоод энэ хоёр шиг хоёр эрэгтэй хүүхэдтэй болсон.
 - **Interpreter:** Эта их младшая дочка. Эти две ребёнка её брата, сестры. Когда она вышла замуж, у неё появились близнецы, похожи на эти две ребёнка.